



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/165

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.3, Дотоодын цэргийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын Тавдугаар бүлгийн “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох (код 510) журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалыг алба хаагчдаар судлуулж, мөрдүүлэх, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/275 дугаар тушаалаар баталсан “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох (код 510) журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.


4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын дарга (цагдаагийн хурандаа Л.Нямдаваа)-д даалгасугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Т.СҮХБОЛД



1500 01 2318

Цагдаагийн ерөнхий газрын даргын
2025 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн
А/115 дугаар тушаалын хавсралт



510.ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ	Батлагдсан огноо:	Дугаар:
Хавсралт: ЦБҮАЖ №510.39, ЦБҮАЖ №510.61.	Нэмэлт тайлбар:	
Тараасан:	Шинэчилсэн:	Хуудас:6

510.1.ЗОРИЛГО

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие даасан цагдаагийн алба хаагч (Individual Police Officer), цагдаагийн тусгай мэргэшсэн баг (Specialised Police Team), цагдаагийн баг (Formed Police Unit)-т үүрэг гүйцэтгэх удирдах бүрэлдэхүүн, алба хаагчдыг сонгон шалгаруулах, сургаж, бэлтгэх, шалгалт зохион байгуулах, нэр дэвшүүлэх, илгээх, хугацааг сунгах, эгүүлэн татах, үүрэг гүйцэтгэлт болон хэрэгжүүлсэн ажлыг үнэлж, дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

510.2.ХАМРАХ ХҮРЭЭ, БОДЛОГО

510.2.1.Алба хаагчийг энхийг дэмжих ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцуулахдаа нээлттэй, ил тод, тэгш эрх, шударга ёсны зарчмаар сонгон шалгаруулах бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баримталж буй (цаашид НҮБ гэх) бодлого, зарчим, үйл ажиллагааны журмыг удирдлага болгоно.

510.2.2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох алба хаагч, тухайн чиглэлээр нарийн мэргэшсэн ажилтан, мэргэжилтнийг Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/120 дугаартай тушаалаар баталсан “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журам”, “Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журам” болон бусад холбогдох эрх зүйн акт, НҮБ-аас гаргасан тогтоол, дүрэм, журам, заавар, гарын авлага, мандатыг мөрдлөг болгон ажиллана.

510.2.3.Цагдаагийн төв байгууллагын Энхийг сахиулах ажиллагаа хариуцсан нэгж нь алба хаагчийг сонгон шалгаруулах, энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ажлын явц, үр дүнг танилцуулах, энхийг дэмжихтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг хариуцна.

510.2.4.Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн Энхийг дэмжих ажиллагааны сургалт, бэлтгэлийн нэгж нь алба хаагчийг ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэлд хамруулах ажлыг хариуцан зохион байгуулна.

510.3.АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧ, БАГИЙГ ШАЛГАЖ ҮНЭЛЭХ, СОНГОХ

510.3.1.Алба хаагчийг дараах төрлөөр сонгон шалгаруулна. Үүнд:

- а/Бие даасан цагдаагийн алба хаагчаар үүрэг гүйцэтгэх;
- б/Цагдаагийн мэргэшсэн тусгай багт үүрэг гүйцэтгэх;
- в/Цагдаагийн багт үүрэг гүйцэтгэх.

510.3.2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг шалгаж үнэлэх, сонгохдоо Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/120 дугаартай тушаалаар баталсан “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журам”-ыг баримтална.

510.3.3.Цэргийн багт үүрэг гүйцэтгэх цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийг Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх дүрэм, журмыг баримтлан сонгон шалгаруулалт явуулна.

510.3.4.Цэргийн багт үүрэг гүйцэтгэх, цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийг оролцуулах тухай цагдаагийн төв байгууллагын саналыг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Зэвсэгт хүчний жанжин штабт хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

510.3.5.Цагдаагийн төв байгууллагын Энхийг дэмжих ажиллагаа хариуцсан нэгж нь бие даасан цагдаагийн алба хаагчийг сонгон шалгаруулах НҮБ-ын Цагдаагийн албаны Дэмжлэг, үнэлгээний баг (SAAT), цагдаагийн багийг үнэлэх НҮБ-ын Цагдаагийн албаны Үнэлгээ, зөвлөгөөний баг (AAV), Үйл ажиллагааны чадавхын үнэлгээ хийх баг (АОС)-ийг Монгол Улсад урьж, сонгон шалгаруулалт, үнэлгээний айлчлалыг зохион байгуулах хүсэлтийг Гадаад харилцааны яам, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газраар уламжлуулан НҮБ-ын Цагдаагийн албанд хүргүүлнэ.

510.3.6.Цагдаагийн төв байгууллагын Энхийг дэмжих ажиллагаа хариуцсан нэгж нь энэ журмын 510.3.5-д заасан үнэлгээний багийн айлчлал, сонгон шалгаруулалт зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, цагдаагийн төв байгууллагын даргаар батлуулна.

510.3.7.Сонгон шалгаруулалтын шалгалтад хамрагдсан алба хаагчид тухай бүрт үнэлгээ өгөх бөгөөд шалгалтад тэнцсэн эсэх мэдээллийг алба хаагчдад тухай бүр өгнө.

510.3.8.Сонгон шалгаруулалтын явцад шалгалтын дэг зөрчсөн, хуурч мэхлэхийг завдсан, хүндэтгэх шалтгаангүйгээр хоцорсон алба хаагчийг шалгалтаас хасна.

510.3.9.Сонгон шалгаруулалтад оролцох алба хаагчийн хүсэлтийг маягт (ЦБҮАЖ №510.39)-ын дагуу гаргана.

510.3.10.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/120 дугаартай тушаалаар баталсан “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журам”-ын 3.10.4, 3.10.5, 3.10.6-д заасан шалгалт авах материалыг холбогдох алба, нэгжээс боловсруулж, цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар томилогдсон комисст нууцлалыг ханган хүргүүлнэ.

510.3.11.“Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журам”-ын 3.10.1-д заасан шалгалтыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 929-д заасны дагуу авна.

510.3.12.Сонгон шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн алба хаагчийн баримт бичгийг шалгаж, гадаад хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт /унших, бичих, сонсох, ярих чадвар/-ыг зохион байгуулан дүнг авсан онооны дарааллаар эрэмбэлж, босго оноог 60 хувиар тооцно.

510.3.13.Цагдаагийн багт гэр бүлийн гишүүн болох алба хаагчид хамт үүрэг гүйцэтгэх тохиолдолд тухайн алба хаагчдын ар гэрийн хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан үүрэг гүйцэтгэх эсэхийг комисс шийдвэрлэнэ.

Тайлбар: Энэ хэсэгт заасан “гэр бүлийн гишүүн” гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасныг ойлгоно.

510.4.АЖИЛЛАГААНЫ ӨМНӨХ БЭЛТГЭЛ, СУРГАЛТ

510.4.1.Ажиллагааны өмнөх бэлтгэл, сургалтын хөтөлбөрийг цагдаагийн төв байгууллагын даргаар, хичээлийн цаг сэдвийн төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулна.

510.4.2.Сургалтын хөтөлбөрийг НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны өмнөх сургалтын үндсэн материал болон НҮБ-ын Цагдаагийн албаны Энхийг сахиулах ажиллагаа дахь тусгайлан мэргэшүүлэх сургалтын материалыг тус тус үндэслэн боловсруулна.

510.4.3.Гадаад хэлний түвшин тогтоох шалгалтад 60-аас дээш оноо авсан алба хаагчийг ажиллагааны өмнөх бэлтгэл, сургалтад цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар хамруулна.

510.4.4.Ажиллагааны өмнөх бэлтгэл, сургалттай холбогдон гарах зардлыг Санхүү, ар талын алба шийдвэрлэнэ.

510.4.5.Ажиллагааны өмнөх бэлтгэл, сургалт явуулах байр, анги танхим, хангалт үйлчилгээ, сургалтад ашиглах хичээлийн хэрэглэгдэхүүн, галт зэвсэг, сум хэрэгсэл, тээврийн хэрэгслийг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв зохион байгуулна.

510.5.ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ

510.5.1.НҮБ-ын Цагдаагийн албаны Дэмжлэг үнэлгээний багийн зохион байгуулсан сонгон шалгаруулалтад тэнцэж, энхийг сахиулах ажиллагааны нөөцөд бүртгэгдсэн алба хаагчийг “Бие даасан цагдаагийн алба хаагч”-аар нэр дэвшүүлэх саналыг цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

510.5.2.НҮБ-ын Цагдаагийн албанаас 6 сар тутамд шинэчлэл хийгдэн зарлагдсан энхийг сахиулах ажиллагааны ажлын байранд алба хаагчийн ур чадварыг үндэслэн нэр дэвшүүлнэ.

510.5.3.Алба хаагчийг илгээх хүсэлтийг НҮБ-ын Цагдаагийн албанаас гаргасан маягт, бичиг баримтын хамт Монгол Улсаас НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгчийн газраар уламжлуулан НҮБ-ын Цагдаагийн албанд хүргүүлнэ.

510.5.4.Нэр дэвшүүлсэн алба хаагчийг НҮБ-ын Цагдаагийн албанаас баталгаажуулсан тохиолдолд эрүүл мэндийн үзлэг, вакцинд хамруулах ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн үзлэгийн маягт, вакцины гэрчилгээг тус албанд хүргүүлнэ.

510.5.5.НҮБ-ын Цагдаагийн албанаас алба хаагчийг томилсон, ажиллагааны газар оронд нэвтрэх зөвшөөрөл ирүүлсэн тохиолдолд алба хаагчийг энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэхээр цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулж, саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, шийдвэр гаргуулна.

510.5.6.Ажиллагааны газар оронд бие даасан болон мэргэшсэн багийн алба хаагчдыг хариуцах Үндэсний ахлахын үүргийг хамгийн өндөр цол эсхүл албан тушаалтай алба хаагч хэрэгжүүлнэ.

510.5.7.НҮБ-ын Цагдаагийн албанаас алба хаагчийн үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах, дуусгавар болох санал ирүүлсэн тохиолдолд цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулж, саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, шийдвэр гаргуулж, шийдвэрийн талаар хариуг НҮБ-ын Цагдаагийн албанд хүргүүлнэ.

510.5.8.Алба хаагч нь энхийг сахиулах ажиллагаанд оролцох үедээ Монгол Улсын хууль тогтоомж, НҮБ-ын дүрэм, олон улсын гэрээ, тухайн ажиллагааны удирдлагаас тогтоосон дүрэм, журам, хэм хэмжээг дагаж мөрдөн, ажиллагаа явагдаж байгаа улсын хууль тогтоомж, ёс заншлыг хүндэтгэнэ.

510.5.9.Энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа бие даасан болон мэргэшсэн тусгай багийн алба хаагч, цагдаагийн багийн удирдлага 6 сар, 12 сараар энхийг сахиулах ажиллагаанд оролцсон ажлын тайлан гаргаж, цагдаагийн төв байгууллагын Энхийг сахиулах ажиллагаа хариуцсан нэгжид ирүүлнэ.

510.5.10.Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчийн ажлын тайланд үнэлэлт дүгнэлт өгч, цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулан шагнаж урамшуулах, авч хэрэгжүүлэх саналыг шийдвэрлүүлнэ.

510.5.11.Энхийг сахиулах ажиллагаанд оролцож байхдаа гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, сахилгын зөрчил гаргасан алба хаагчид хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх, эрүүл мэндийн байдал, ар гэрийн шалтгаанаар үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд эгүүлэн татах асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

510.6.ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ БАТАЛГАА

510.6.1.Энхийг сахиулах ажиллагаанд томилогдсон алба хаагчаас ар гэрийн зөвшөөрөл (маягт ЦБҮАЖ № 510.61)-г бичгээр гаргуулна.

510.6.2.Алба хаагчаас ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэх хугацаанд орон нутгийн иргэд (ялангуяа хүүхэд, эмэгтэй хүн), НҮБ-ын алба хаагч нарт сэтгэл зүйн, биеийн болон бэлгийн хүчирхийлэл үйлдэхгүй, аливаа садар самуун, ёс суртахуунгүй үйлдлээс зайлсхийх, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэхгүй, бусдад дамжуулахгүй байх баталгааг бичүүлж авна.

510.6.3.Цагдаагийн төв байгууллагын Дотоод хяналт-аюулгүй байдлын нэгж нь энхийг дэмжих ажиллагаанд томилогдсон алба хаагчаас төрийн болон албаны нууцын баталгаа гаргуулан авна.

510.6.4.Үүрэг гүйцэтгээд ирсний дараа алба хаагчид өөрийн хүсэлтээр ээлжийн амралт олгох, нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх, сувилуулах арга хэмжээг “Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журам”-ын дагуу зохион байгуулна.

510.6.5.Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийн албан тушаалыг хэвээр хадгалж, цалин хөлсийг бүрэн олгоно. Цалин хөлсийг алба хаагчаас гаргасан хүсэлтийг үндэслэн итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгож болно.

510.6.6.Алба хаагчийн үүрэг гүйцэтгэх хугацаанд хоёр ээлжийн өдөр тутмын дүрэмт хувцас, шаардлагатай хэрэгсэл, хэрэглэлээр хангах, олгох ажлыг Санхүү, ар талын алба зохион байгуулна.



**ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД
ХАМРАГДАХ, ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ ТУХАЙ**

..... он сар өдөр хот

..... албан тушаалтай, цагдаагийн цолтой овогтой миний бие Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цагдаагийн албаны Дэмжлэг үнэлгээний багийн сонгон шалгаруулалт, Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журмыг баримтлах сонгон шалгаруулалтад тус тус хамрагдах, үүрэг гүйцэтгэхэд өөрийн хүсэлт, сайн дурын үндсэн дээр оролцох хүсэлтэй байна.

1.Регистрийн №: 2.Гадаад паспортын №:

Төгссөн сургууль /хамгийн сүүлд төгссөн огноог эхэнд нь бичих/:

д/д	Сургуулийн нэр	Төгссөн огноо	Мэргэжил, боловсрол

Гадаад хэлний мэдлэг:

д/д	Хэлний төрөл	Хаана, хэзээ аль шатны сургууль, дамжаанд хамрагдсан

Энхийг дэмжих ажиллагааны туршлага:

д/д	Аль улсад, ямар ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн	Үүрэг гүйцэтгэсэн огноо, хугацаа	Ямар албан тушаалд

Хүсэлт гаргасан: гарын үсэг

Байгууллагын даргын шийдвэр /хүсэлтийг зөвшөөрсөн эсэх, байгууллагын тэмдэг дарах/:

.....
.....

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ
АЛБА ХААГЧИЙН АР ГЭРИЙН ЗӨВШӨӨРӨЛ

20 оны сарын өдөр

..... хот

..... Улсад явагдаж байгаа НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр сайн дурын үндсэн дээр хүсэлт гаргаж, томилогдсон алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын албан тушаалтай, цагдаагийн цолтой, овог нэр -ын ар гэрийг төлөөлөн /эцэг, эх, эхнэр, нөхөр, төрсөн ах, төрсөн эгч/ (доогуур зурах) би энэ ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэхийг зөвшөөрч, баталгаа гаргаж байна.

НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх явцад учирч болзошгүй аливаа эрсдэлийг ойлгож, хөдөлмөрийн чадвар, амь насаа алдах тохиолдолд ар гэрийн зүгээс ямар нэгэн гомдолгүй.

АР ГЭРИЙГ ТӨЛӨӨЛЖ:

..... овогтой нэр

Регистрийн дугаар:

Оршин суугаа гэрийн хаяг, утасны дугаар:

.....
.....

---oOo---